



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2013 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үүрэг хэрэгжүүлэх тухай

“Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөн” зохион байгуулсантай холбогдуулан 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч нарт өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх албадын дарга нарт ДААЛГАХ нь:

1. Гүйцэтгэлийн хувийн хэргийн нэгдсэн дугаарлалт, цахим бүртгэлийн сангийн мэдээлэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэх баримт бичиг нэг бүрт нэгдсэн дугаар олгож, цахим санд мэдээлэлийг тухай бүр оруулах,

2. Шийдвэр гүйцэтгэлийн төрөлжсөн мэдээ, судалгааг тухайн албаны цахим бүртгэл, нэгдсэн дугаартай тулгаж, сар, хагас, бүтэн жилийн мэдээ, судалгааг албаны дарга биечлэн хянаж баталгаажуулан ирүүлэх,

3. Орон нутаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын дарга нараас шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байгаагаас бодит биелэлтэд нөлөөлж байна. Тухайлбал: Шийдвэр гүйцэтгэх албадын дарга нар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад автомашин хэрэглүүлдэггүй, сум багуудад томилолтоор ажиллуулаагүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадах ажиллагааны зардалд хязгаарлалт тогтоон зарцуулах эрх олгосон байна.

Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулах, хууль, журамд заагаагүй үндэслэлээр албадан гүйцэтгэх ажиллагааны зардалд хязгаарлалт тогтоохгүй байх,

4. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй олон төлбөр авагчтай гүйцэтгэлийг эцэслэн шийдвэрлэх талаар хуульд заасан бүхий л арга хэмжээг авч, хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх мэдэгдэл өгснөөр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хязгаарлахгүй байх, хойшлуулшгүй ажиллагааг явуулах,

5. Ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч нар өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарал хандуулж, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагатай нийцэж ажиллах дадал, ур чадвар эзэмших,

6. Төрийн үйлчилгээг анхан шатанд үзүүлж байгаа ахлах болон шийдвэр гүйцэтгэгч нар үйл ажиллагаагаа шинэ шатанд гаргаж, иргэдтэй харилцах зан харьцаа, ёс зүй, ажил үүрэгтээ хандах хандлагыг өөрчлөх, ёс зүйн болон аливаа зөрчилд холбогдохгүй байх,

7. Шийдвэр гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгааг дээшлүүлэх, тэднийг тогтвортой ажиллуулах нөхцөл бололцоогоор ханган ажиллах,

8.Шинээр томилогдсон шийдвэр гүйцэтгэгч нарыг тухайн тойргийн материалтай богино хугацаанд танилцуулах, үүрэгт ажилд нь дадлагажуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх арга хэмжээ авах,

9.Нийт гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг жигд явуулах, зохих журмын дагуу гүйцэтгэх баримт бичигт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг орхигдуулсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид олгогдох урамшууллыг хойшлуулах,

10.Шүүхийн шатанд байгууллагыг хариуцагчаар татсан тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчээс боломжит бүхий л арга хэмжээг авч төлөөллийг хэрэгжүүлэн оролцох, байгууллагад учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх ажлыг зохион байгуулах,

11.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад хуулиар олгосон эрх, үүргийг тайлбарлах, өргөдөл, гомдолд хариу өгсөн байдлаар хянан шийдвэрлэх ажиллагааг хязгаарлахгүй байх, тэдний хүссэн мэдээлэлд үндэслэл бүхий хариу өгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцыг тайлбарлан өгөх,

12.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шуурхай байдлыг нэвтрүүлэх чиглэлээр өөрийн харьяа төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой ажиллах, тэдний дэмжлэг туслалцааг авч, үйл ажиллагаанд нэвтрүүлэх,

13.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нар өөрийн харьяаллын шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биечлэн гүйцэтгэж, маргааныг эцэслэн шийдвэрлэх,

14.Хорихоос өөр төрлийн ялын биелэлтийг ахиулах, ялтанд ял завших боломжийг олгохгүй байх,

15.Дампуурсан банкуудтай холбоотой шүүхийн шийдвэрт үр дүн гаргаж, он удаан жил болж буй гүйцэтгэлийн материалыг эцэслэн шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах,

16.Ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, шинээр томилогдож буй шийдвэр гүйцэтгэгч нарт ажил хүлээлцүүлэх үйл ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгч нар хяналтад авч, бүртгэлийн сангийн мэдээлэлтэй тулгалт хийн ажил хүлээлцэх,

Дээрх үүрэг, даалгаврыг заалт нэг бүрээр хэрэгжүүлэх ажлыг тухайн албанд зохион байгуулж, 2013 оны 2, 3, 4 дүгээр улирлын байдлаар үр дүнг нэгтгэн тооцож, дүнг Шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлэхийг Та нөхдөд үүрэг болгож байна.

ДАРГА, ХУРАНДАА



Д.ЯДАМДОРЖ